



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВ**

13335 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Нам Ян Жугийн гудамж 32/1, Утас: 45 39 94,
Факс: (976-11) 45 86 99, E-mail: info@nccd.gov.mn,
<http://www.nccd.gov.mn>

2022.04.26 № 7/667.
танай _____-ны № _____-т

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР,
ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ, НЭГДСЭН
ЭМНЭЛЭГ БОЭТ, УХТЭ, ТТАХЭ,
ЦТЭ, УЛААНБААТАР
ТЗНЭ-ИЙН ДАРГА НАРТ

Тандалт, судалгааг эрчимжүүлэх тухай

Коронавируст халдвараар 2022 оны 4 дүгээр сарын 19-ний байдлаар дэлхийн дахинд 500 гаруй сая хүн халдварт өртөж, 6 сая гаруй хүн нас бараад байна. SARS-CoV-2 вирус нь анх мэдэгдэж байсан эх хувилбараасаа хувьсан өөрчлөгдөж, одоогийн байдлаар хүн амд аюул учруулахуйц 5, анхаарал татаж буй 8 хувилбарыг ДЭМБ албан ёсоор бүртгээд байна. Эдгээр хувилбаруудаас Дельта болон Омикрон хувилбар идэвхтэй орчилд байгаа ба Омикрон хувилбарын BA.1, BA.2 хувилбар халдварын дэгдэлтийн гол шалтгаан болж байна.

Манай төв нь 2022 оны 1 дүгээр сараас SARS-CoV-2 вирусийн хувилбарын тандалтыг хийж эхэлсэн. Хувилбарын тандалтыг хийснээр өөрийн улсад вирусийн хувилбарын дамжин тархах хурд, үүсгэж буй эмнэлзүйн хэлбэр зэргээс хамаарч эмнэлзүйн болон нийгмийн эрүүл мэндийн хариу арга хэмжээг авах боломж бүрдсэн. Орон нутгаас ирүүлсэн SARS-CoV-2 вирус эерэг нийт сорьцын 77% нь хувилбарын тандалтын шинжилгээний шалгуурыг хангахгүй байгаа тул стандарт вирус тээвэрлэх орчинд ашиглах шаардлагатай байна.

Цаашид SARS-CoV-2 вирус хэрхэн хувьсах, бусад улс оронд бүртгэгдэж буй шинэ хувилбар манай улсад тархсан эсэхийг тогтоох үүднээс хувилбарын тандалтыг тогтмол, зөв шуурхай хийх үүднээс түр зааврыг хүргүүлж байна. Энэ заавар нь ЭМС-ын тушаал болон гарах тул хугацаа алдалгүй та бүхэн үйл ажиллагаандаа мөрдлөг болгож, тандалтыг эрчимжүүлж ажиллана уу.

Холбогдох мэдээллийг Томуугийн үндэсний нэгжийн тархвар судлагч эмч нартай 99075707, 99817099, вирус судлалын лабораторийн эмч 99613388 утсаар холбогдон авна уу.

Хавсралт // хуудастай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Ц.БИЛЭГТСАЙХАН

ХӨСҮТ-ийн 2022 оны 7/67 тоот
албан бичгийн хавсралт



SARS-COV-2 ВИРУСИЙН ХУВИЛБАРЫН ТАНДАЛТ ХИЙХ ТҮР ЗААВАР

Нэг. Сорьцод тавигдах шаардлага

1.1. Вирус судлалын шалгуур үзүүлэлт

- 1.1.1. бх-ПГУ шинжилгээ эерэг гарсан Ct утга 25-аас доош байх.
- 1.1.2. 0-18, 19-59, 60< насны бүлэг тус бүрээс 4-өөс доошгүй сорьц байх.
- 1.1.3. Сорьцыг -70 хэмийн гүн хөлдөөгчид хадгалсан байх.

1.2. Тархварзүй, эмнэлзүйн шалгуур үзүүлэлт


- 1.2.1. ТТӨ, АЗЦХХ, коронавируст халдвар (КОВИД-19) оношлогдсон бүх тохиолдлоос
- 1.2.2. Нэмэлтээр дараах тохиолдлоос сорьц авч шинжилнэ.
 - 1.2.2.1. Өмнө нь КОВИД-19-өөр өвдсөн, SARS-CoV-2 вирусийн халдвар авсан болох нь батлагдсан тохиолдол;
 - 1.2.2.2. Дархлаа дарангуйлагдсан амьсгалын замын халдварын шинж тэмдэг илэрсэн тохиолдол
 - 1.2.2.3. Эмнэлзүйн өвөрмөц шинж тэмдэг бүхий тохиолдлын кластер
 - 1.2.2.4. АЗЦХХ-ын шалтгаантай хүнд, маш хүнд, нас барсан тохиолдол
 - 1.2.2.5. Шалтгаан тодорхойгүй АЗЦХХ-ын улмаас нас барсан тохиолдол (уушгины эд авах)
 - 1.2.2.6. Хүн амд аюултай SARS-CoV-2 вирусийн хувилбарын тархалт өндөртэй газар нутгаар сүүлийн 14 хоногт явсан, аялсан хүмүүс

Хоёр. Хувилбарын тандалтанд сорьц ирүүлэх заавар

- 2.1. Аймаг, дүүргийн вирус судлалын лаборатори нь SARS-CoV-2 вирус илрүүлэх бх-ПГУ-ын шинжилгээ хийж, SARS-CoV-2 эерэг тохиолдлоос 1 дүгээр бүлэгт заасан шаардлагыг хангасан 20 хүртэлх сорьцыг сонгож, сорьц тээвэрлэх зааврыг баримтлан 14 хоногт нэг удаа ХӨСҮТ-ийн вирус судлалын лабораторид хүргүүлнэ.
- 2.2. Хилийн боомт бүхий нэгжүүд хилийн боомтын ажилчид, оршин суугчдаас тус бүр 10 хамар залгиурын арчдас сорьцыг сард нэг удаа 0-18, 16-59, 60 болон түүнээс дээш насны бүлгийг төлөөлөхүйц байхаар цуглуулж, ХӨСҮТ-ийн вирус судлалын лабораторид хүргүүлнэ.

Гурав. Мэдээллийн урсгал

- 3.1. Сорьц авсан эмч сорьцын дагалдах хуудсыг бөглөнө.
- 3.2. Вирус судлалын лабораторийн эмч сорьцыг зааврын дагуу гурвалсан савлагаа бүхий тээвэрлэх журмыг баримтлан ХӨСҮТ-ийн вирус судлалын лабораторид хүргүүлнэ.
- 3.3. Хилийн боомт бүхий газраас авсан сорьцыг харъяа сумын Эрүүл мэндийн төвийн эмч гурвалсан савлагаа бүхий тээвэрлэх журмыг баримтлан ХӨСҮТ-ийн вирус судлалын лабораторид хүргүүлнэ.
- 3.4. Аймаг, нийслэлийн вирус судлалын лаборатори нь хувилбарын тандалтын зорилгоор сонгосон сорьцын мэдээллийг "Маягт 1"-ын дагуу бичиж "Microsoft

- 
- Excel” программ дээр шивэн virologylabmng@gmail.com хаягаар, сорьцын хамт, сорьц тээвэрлэх зааврыг баримтлан вирус судлалын лабораторид хүргүүлнэ.
- 3.5. Хувилбарын тандалтын шинжилгээний хариуг ХӨСҮТ-ийн вирус судлалын лаборатори нь Томуугийн үндэсний нэгжид nicmongolia@gmail.com цахим хаягаар мэдээлэх ба сорьц ирүүлсэн вирус судлалын лабораториудад эргэн мэдээллийг цахим хаягаар хүргүүлнэ.

Дөрөв. Сорьц цуглуулах, хадгалах, тээвэрлэх заавар

- 4.1. Хувилбарын тандалтанд хамруулах шаардлагатай өвчтөнөөс эмчилгээ эхлэхийн өмнө сорьц авна.
- 4.2. Тохиолдол бүрээс хамар-залгиурын арчдас, ам-залгиурын арчдас, амьсгалын доод замын хүнд хэлбэрийн өвчтэй бол цэр, амьсгалын гуурстай бол мөгөөрсөн хоолойн сордос, мөгөөрсөн хоолой-альвеолын лаваж, нас барсан тохиолдолд уушгины эдийг ЭМС-ын 2022 оны А/36 дугаар тушаалын 7 дугаар хавсралтад заасан сорьц авах зааврыг баримтлан авна.
- 4.3. Сорьц хадгалах, тээвэрлэх заавар
- 4.3.1. Сорьц тээвэрлэх зардлыг тухайн сорьц илгээж буй эрүүл мэндийн байгууллага бүрэн хариуцна.
- 4.3.2. Сорьцыг стандарт вирус тээвэрлэх орчинд авч, хадгалж, тээвэрлэнэ.
- 4.3.3. Вирус тээвэрлэх орчныг тухайн эрүүл мэндийн байгууллага тасралтгүй хангана.
- 4.3.4. Хамар-залгиурын арчдас, ам-залгиурын арчдас, уушгины эдийг 24-48 цагийн дотор мөсөн элемент бүхий саванд хийж, +2-оос + 8 хэмд, 48 цагийн дотор тээвэрлэх боломжгүй бол -70°C хэмд хадгалж, хөлдүүгээр нь харъяа лабораторид хүргүүлнэ.
- 4.3.5. ХӨСҮТ-ийн вирус судлалын лабораторид сорьцыг ирүүлэхдээ -70°C хэмд хадгалж, хөлдүүгээр тээвэрлэн хүргүүлнэ.
- 4.3.6. Сорьцыг тээвэрлэхийн өмнө ХӨСҮТ-ийн вирус судлалын лабораторийн 451183, 455847 дугаарын утсаар, орон нутагт бол харъяа лабораторид урьдчилан мэдэгдэнэ.
- 4.3.7. Сорьцыг асгарахаас сэргийлэн биоаюултай илгээмж, биобэлдмэл тээвэрлэх журмын дагуу гурвалсан баглааны зарчмыг баримтална. Сорьц цуглуулсан савны гадуур амыг нь битүүмжлэх боломж бүхий уутанд хийж, гадна талд нь “Биоаюултай”, “Халдвартай” гэсэн тэмдэглэгээг хийж тээвэрлэнэ. Сорьцыг шингээгч цаас болон самбайгаар ороон жийрэглэж хоёрдогч саванд хийнэ. Хэд хэдэн сорьцыг хоёрдогч саванд хийж болно. Ингэхдээ тус тусад нь шингээгч материалаар орооно. Уг сорьцоо тусгай пластик саванд хөдөлгөөнгүй байрлуулж таглаад мөсөн элемент бүхий гуравдагч саванд сорьцыг босоо байрлуулна.
- 4.3.8. Сорьцын дагалдах хуудсыг гаргацтай, бүрэн бөглөж, сорьцын хамт хүргүүлнэ.



Тав. Сорьцын дагалдах болон мэдээллийн хуудас

Маягт 1. Сорьц дагалдах хуудас №...../.....

Эрүүл мэндийн байгууллагын нэр
Өвчтөний овог/нэр
Нас:, Хүйс: Эрэгтэй , Эмэгтэй
Гэрийн хаяг:
Эмнэлзүйн онош:
Өвчин эхэлсэн огноо: _____ оны __ сарын __ өдөр
Эмнэлэгт хэвтсэн огноо: _____ оны __ сарын __ өдөр
Сорьц авсан огноо: _____ оны __ сарын __ өдөр __цаг __ минут
Сорьц авах үеийн биеийн хэм: °C
Цуглуулсан сорьцын төрөл: Хамар-залгиурын арчдас
Ам-залгиурын арчдас
Мөгөөрсөн хоолойн сордос
Бусад

Сорьцыг тээвэрлэлтэнд өгсөн огноо: _____ оны __ сарын __ өдөр __цаг __ минут
Сорьц авсан эмч, сувилагчийн нэр:

Маягт 2. SARS-CoV-2-ын хувилбар тандах зорилгоор ирүүлж буй сорьцыг дагалдаж ирэх мэдээлэл

Сорьцын мэдээлэл:
Сорьцын тусгай дугаар: <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/>
Сорьцын төрөл: <input type="checkbox"/> Хамар-залгиурын арчдас; <input type="checkbox"/> Ам-залгиурын арчдас; <input type="checkbox"/> Цэр; <input type="checkbox"/> Эд, эсийн сорьц
Сорьц цуглуулсан огноо: <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> - <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> - <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/>
Сорьц цуглуулсан аймаг/хотын нэр: _____
Анх оношилсон лабораторийн нэр: _____
Геномын дараалал тогтоосон лабораторийн нэр: _____
Түүвэрлэлтийн арга: <input type="checkbox"/> Хүн амын дундаас; <input type="checkbox"/> Өвөрмөц тохиолдлоос; <input type="checkbox"/> Тандалтын зорилгоор /шинж тэмдэгтэй үйлчлүүлэгч/
Хүн ам зүй, аяллын мэдээлэл:
Нас <input type="checkbox"/> ; Хүйс: <input type="checkbox"/> эр; <input type="checkbox"/> эм
Үндэс, угсаа: _____
Эрүүл мэндийн ажилтан эсэх: <input type="checkbox"/> тийм; <input type="checkbox"/> гүй



Аяллын түүх: сүүлийн 14 хоногт зорчисон газрууд: _____
Өвчлөлийн тухай мэдээлэл:
Ашигласан бх-ПГУ шинжилгээний төрөл (хэрэв ашигласан бол): _____
бх-ПГУ Ct утга (хэрвээ байгаа бол): _____
Шинж тэмдэгтэй эсэх: <input type="checkbox"/> тийм; <input type="checkbox"/> үгүй Тийм бол шинж тэмдэг эхэлсэн огноо: <input type="text"/> - <input type="text"/> - <input type="text"/> Тийм бол шинж тэмдэгийг бичих: _____
Вакцинжуулалтын байдал: 1-р тунгийн огноо: <input type="text"/> - <input type="text"/> - <input type="text"/> 2-р тунгийн огноо: <input type="text"/> - <input type="text"/> - <input type="text"/> 3-р тунгийн огноо: <input type="text"/> - <input type="text"/> - <input type="text"/> 4-р тунгийн огноо: <input type="text"/> - <input type="text"/> - <input type="text"/>
Эмнэлэгт хэвтсэн эсэх: <input type="checkbox"/> тийм; <input type="checkbox"/> үгүй Тийм бол огноо: <input type="text"/> - <input type="text"/> - <input type="text"/>
Эрчимт эмчилгээний тасагт эмчлүүлсэн эсэх: <input type="checkbox"/> тийм; <input type="checkbox"/> үгүй Тийм бол огноо: <input type="text"/> - <input type="text"/> - <input type="text"/>
Механик вентилаци хийлгэсэн эсэх: <input type="checkbox"/> тийм; <input type="checkbox"/> үгүй Тийм бол үр дүн: _____
Өмнө нь SARS-CoV 2 халдвар авсан эсэх Тийм бол огноо: <input type="text"/> - <input type="text"/> - <input type="text"/>
Тухайн үед хийлгэсэн эмчилгээг бичих: _____
Кластер өвчлөлтэй холбоотой эсэх: <input type="checkbox"/> тийм; <input type="checkbox"/> үгүй Тийм бол кластерын нэр, төрөл: _____ Кластерт бүртгэгдсэн тохиолдлын тоо: _____
Тээгч амьтантай харьцсан эсэх: <input type="checkbox"/> тийм; <input type="checkbox"/> үгүй Тийм бол ямар амьтан /бичих/: _____
Хавсарсан өвчинтэй эсэх: <input type="checkbox"/> тийм; <input type="checkbox"/> үгүй Тийм бол /бичих/: _____